



Аймгийн ИТХ-ын менежер  
Р.Тунгалаг-Эрдэнэ

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

915 Дархан, Дархан-Уул  
Бурхантын хөндийн гудамж  
Утас: 7037-3089, Факс: 7037-3089

2014.06.02 № 01/38  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Төлбөр хариуцуулах тухай**

Үндэсний Аудитын газраас УИХ-д ирүүлсэн өргөдөл гомдлыг шалгах ажлын хэсгийн шалгалтаар Дархан-уул аймгийн ИТХ төсвийн хөрөнгөөр гадаадад тэргүүлэгчдээ явуулсан гэснийг шалгалгахад тус аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжаар тэргүүлэгч 7 хүнийг 5 дугаар сарын 2-ноос 7-ныг хүртэл Арабын Нэгдсэн Эмират улсын Дубай хот хотод явуулахад 18,2 сая төгрөг зарцуулсан байв.

Энэ нь урьдчилан төлөвлөгдөөгүй, төсвийн тодотголд ИТХ-ын төсвийн гадаад арга хэмжээний зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн батлуулж, гадаадад аялуулсан, томилолтоор ажилласан тэргүүлэгчид тухайн улсын ямар нэгэн байгууллага газартай албан ёсны уулзалт, гэрээ, хэлцэл хийсэн нь баримтаар нотлогдохгүй байгаагаас үзэхэд Төсвийн тухай хуулийн 6.4.1-т: "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалт, Санхүү эдийн засгийн сайдын 2001 оны 188 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад томилолтын төсвийг зохиох, хянах, санхүүжүүлэх, тайлагнах журам"-ыг зөрчсөн зөрчил илэрлээ.

Төрийн Аудитын тухай хуулийн 15.1.12-т "**Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх**" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

ИТХ-ын төсвөөс гадаадад томилолтод зүй бусаар зарцуулсан 18,2 (Арван найман сая хоёр зуун мянган) төгрөгийг 2014 оны 6 дугаар сарын 25-ны дотор аймгийн Төрийн сан банкны Аудитын газрын 190051405 тоот дансанд оруулахыг ИТХ-ын менежер Р.Тунгалаг-Эрдэнэ, нягтлан бодогч Б.Амархүү нарт хариуцуулан акт тогтоов.

АКТ

ТОГТООСОН:

ҮАГ-ЫН ХАРЬЯА ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Ц.ОТГОНСҮХ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ИТХ-ЫН МЕНЕЖЕР

НЯГТЛАН БОДОГЧ

Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ

Б.АМАРХҮҮ

ТТО.0507

**АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛСЫН ДУБАЙ ХОТОД ТУРШЛАГА  
СУДЛАХ АЖЛААР ЯВСАН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИТХ-ЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НЭРС**

| <b>№</b> | <b>Овог нэр</b> | <b>Эрхэлдэг ажил</b>                      | <b>Намын харъяалал</b> | <b>Албан тушаал</b> |
|----------|-----------------|---|------------------------|---------------------|
| 1        | Б.Азжаргал      | Дархан сумын Засаг дарга                  | МАН                    | Тэргүүлэгч          |
| 2        | Г.Батбаяр       | Дархан сумын Засаг даргын орлогч          | МАН                    | Тэргүүлэгч          |
| 3        | Б.Бат-Эрдэнэ    | Аймгийн МАХН-ын дарга                     | МАХН                   | Тэргүүлэгч          |
| 4        | П.Эрдэнэбат     | “Манх халдун”ХХК-ны гүйцэтгэх захирал     | АН                     | Тэргүүлэгч          |
| 5        | Б.Даваасамбуу   | “Өгөөж чанар”ХХК-ны захирал               | Бие даагч              | Тэргүүлэгч          |
| 6        | М.Төмөртоогоо   | Дархан төмөрлөг ТӨХК-ны ерөнхий менежер   | АН                     | Тэргүүлэгч          |
| 7        | Г.Эрдэнэбат     | “Дархан барилга захиалагч” ОНӨҮГ-ын дарга | МАН                    | Тэргүүлэгч          |